

Товч мэдээлэл

Төслийн нэр:	“Харуул толгойн” хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлох төсөл
Төслийн Байршил:	Дорнод аймаг Матад сум
Төсөл хэрэгжүүлэгч:	“Ханзо майнинг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	“Ханзо майнинг” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011811325, Регистрийн дугаар: 6258832
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Хүннүгийн гудамж Парадайс плаза 10 давхар
Утас:	+976-11- 95100426
Факс:	+976-11-
Цахим хаяг:	envr@khashaatcoal.mn , envrhanzo@gmail.com
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн Утас: 95100426
БОНЕУ, шийдвэрийн төсөл:	№12/3531, 2024 оны 8-р сарын 01-ны өдөр БОНЕУ-ний дүгнэлтийг гаргасан.
БОННУ хийсэн ААН-ийн Нэр, батлуулсан огноо:	Тус төслийн БОННУ-г “Грийн ассесмент” ХХК хийж гүйцэтгэсэн. 2025 он

Агуулга

1. Төслийн товч танилцуулга
 - 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл
 - 1.2 Төслийн талбайн засаг захиргааны харьяалал
 - 1.3 Дэд бүтэц зам харилцаа
 - 1.4 Ажиллах хүчний тухай мэдээлэл
2. Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдал
 - 2.1 Газар зүйн бүсчлэл
 - 2.2 Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт
 - 2.3 Гадаргын болон газар доорх ус
 - 2.4 Хөрсөн бүрхэвч
 - 2.5 Ургамалан нөмрөг
 - 2.6 Амьтаны аймаг
3. Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
 - 4.1 Төслийн технологийн үе шаттай холбогдох нөлөөлөл
5. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт
 - 5.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
 - 5.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
 - 5.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
 - 5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
 - 5.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
 - 5.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө
 - 5.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
 - 5.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
 - 5.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
 - 5.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогц, сонирхогч талуудад тайлагнах хуваарь
6. Хавсралтууд

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн нэр:

“Харуул толгойн” нэртэй хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах төсөл

1.2.Төслийн эрхэм зорилго:

Харуул толгойн нэртэй хүрэн нүүрсний ордыг байгаль орчинд аль болох сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан Монгол улсын эрдэс баялгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, улс орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд төслийн гол зорилго оршино.

1.3.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын товч танилцуулга:

“Ханзо майнинг” ХХК нь Монгол улсын 9011811325 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй. Ашигт малтмал газрын тосны газраас “Ханзо Майнинг” ХХК-д 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Харуул толгойн нэртэй газарт 3,310.89 гектар талбай бүхий талбайд ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон байна.


Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дугаар MV-022816

1.4.Төслийн байршил


“Ханзо Майнинг” ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших MV-022816 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Харуул толгойн хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 747 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 85 км, Матад сумын төвөөс 125 км, Хавирга хилийн боомтоос 90 км зайд БНХАУ-тай хиллэдэг.

Хүснэгт 1.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн газарзүйн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	115	34	2.15	47	53	17
2	115	34	2.15	47	52	24.39
3	115	35	10	47	52	24.39
4	115	35	10	47	51	6
5	115	32	55	47	51	4.5
6	115	32	55.24	47	48	41.85
7	115	32	55.25	47	48	41.85
8	115	32	55.25	47	48	41.85
9	115	36	2.54	47	48	41.85
10	115	36	2.54	47	48	1.93
11	115	31	2.53	47	48	1.94
12	115	31	2.53	47	52	24.39
13	115	32	48.45	47	52	24.39
14	115	32	48.45	47	53	17



Зураг 1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил зааг харуулсан зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн байршилын зураг

1.5. Төслийн талбайн засаг захиргааны харьяалал

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос 747 км, Чойбалсан хотоос урагш 85 км, Матад сумын төвөөс хойш 125 км-т оршино. Тусгай зөвшөөрлийн талбай нь БНХАУ-тай хиллэдэг Хавирга хилийн боомтоос 90 км зайтай.

г.Сумын хүн ам нь 2596, засаг захиргааны 4 багтай, 95000 толгой малтай. Сумын төвд хувийн хэвшлийн байгууллага, ерөнхий боловсролын сургуультай, соёлын төв, шуудан холбоо тус тус үйл ажиллагаа явуулж байна. Төслийн талбай нь сумын төвөөс зайтай,

хилийн хориотой бүсд барладаг учих хүн амын нягтрал сийрэг, Халх гол сумруу явдаг ердийн шороон замаас – км зайд байрлана.

1.6. Дэд бүтэц зам харилцаа

Матад сум нь Улаанбаатар хотоос 720 км, Чойбалсан хотоос 150 км алслагдсан. Зам харилцааны хувьд сайн шороон замуудтай. Шилэн кабель, үүрэн холбооны станц, засаг захиргааны байгууллагууд, эмнэлэг, сургууль, худалдаа үйлчилгээний төвүүд, олон нэр төрлийн дэлгүүрүүд олонтой, зүүн бүсийн төвийн шугамд холбогдсон, шатахуун түгээх станц ажилладаг. Улаанбаатар хотоос Дорнод аймгийн Чойбалсан хот хүртэл 593 км хатуу хучилттай засмал замтай бөгөөд түүнээс цааш орон нутгийн сайжруулсан шороон замтай.

Тусгай зөвшөөрлийн талбай нь зүүн Монголын эдийн засгийн бүст хэдийгээр хамрагдах боловч дэд бүтэц төдийлөн сайн хөгжөөгүй байна.

1.7. Ажиллах хүчний тухай мэдээлэл

Ажилчидын орон тоог төслийн хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрээс хамааруулан гаргасан. Нийт ажиллагсдыг зэрэглэлд хуваан ангилж, дотроо уурхайн болон уурхайн бус ажилчдын ажиллах нөхцлийг тусгуулан оруулж, цалингийн санг өөр хоорондоо ялгаатай байхаар тодорхойлсон. Цалингийн сан нь үндсэн, шагналт урамшуулал гэсэн хэсгээс бүрдэнэ. Ажиллагсдыг орон нутгийн иргэдээс ихэнхийг бүрдүүлэх юм.

Төслийг хэрэгжүүлснээр жил тутам 195-363 хүний тогтмол ажлын байр бий болно. Хоногт 12 цагийн 2 ээлжээр, вахтын аргаар зохицуулагдана.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газар зүйн бүсчлэл

Төслийн талбайн гадаргуугийн ангилалаар Дорнод Монголын мужийн Мэнэнгийн талын дэд мужид хамаарах бөгөөд элэгдэл, хуримтлалын гадаргын шилжилтийн хэсэгт оршино. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн дүүрэг нь 1000 м-ээс доош үнэмлэхүй өндөршилтэй намдуу талын хэв шинжид хамаарах Дорнод Монголын хуримтлалын гадаргуугийн баруун зах түүний салбар жижиг хотгорт хамаарна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн сансрын зураг 3-т үзүүлээ.



Зураг 3. Төслийн талбайн байр зүйн зураг

2.2. Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нэлээд өргөгдсөн тэгш өндөрлөгт хамаарах бөгөөд дэлхийн уур амьсгалын бүсчлэлээр хойд сэрүүн бүсэд харьяалагдан, далай тэнгисийн зүгээс ирэх чийглэг дулаан амьсгал Хянганы уулсаар хаагдсаны улмаас эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилд унах хур тунадасны хэмжээ бага байдаг. Судалгааны талбайн (ер нь Дорнод Монголын) цаг уурын төлөв байдал нь нэгэнт эх газрын эрс тэс шинжтэй тул өвлийн улирал нь урт хүйтэн, зун нь богино дулаан, харин хавар намрын улирал нь богиновтор хэр нь хүйтний солилцоо их байдаг.

Хамгийн дулаан байх үе нь 7-р сард, хүйтэн нь 1-2-р сард тохиолдоно. Жилийн дундаж температур нь $0+2^{\circ}\text{C}$ ба хамгийн хүйтэн байх 2-р сарын дундаж температур -20° байдаг. Баруун хойноос болон зүүн хойд чиглэлийн салхи зонхилох ба Төв азийн Сибирийн максимумаас үүсэлтэй антициклон голлох үүрэгтэй. Үуны эхнээс өндөр даралттай муссон салхины үе эхэлдэг. Жилийн туршид салхитай өдрүүд зонхилдгоос хөрсний чийгшил маш муу, хуурайшилт ихтэй. Жилийн ихэнх өдрүүд нь цэлмэг нартай байдаг бөгөөд өвөл цас их унасан үед агаарын чийглэг 70-80% хүрэх ба зуны хамгийн чийглэг хур борооны үе 8-р сард ч агаарын чийглэг 40%-иас хэтрэхгүй. Хур тунадасны дундаж уналт 180-210 мм орчим бөгөөд, хамгийн их унах үе нь 7 сард 250 мм хүрдэг.

2.3. Гадаргын болон газар доорх ус

Нуурын болон гадаргуугын усны тархалтын хувьд маш дутмаг. Төв азийн гадагш болон тогтмол урсгалгүй гол мөрний дүүрэгт (Мэнэнгийн ай сав) хамаарна. Хайгуулын талбайн хэмжээнд гол горхи байхгүй хур тунадсаар тэжээгдэх давстай нуур тойрмууд байх ба хур бороо ихтэй жилүүдэд ширгэдэг. Дүүргийн усан хангамж нь цаг уураас шууд хамааралтай ба гантай жил бараг урсгалгүй болон хатах явдал байдаг. Хашаат цайдам, Баян усны, Их халуун шавар, Бага халуун шаварт зэрэг нуурууд бий. Мөн эрдэсжилт ихтэй гар худгууд байдаг. Нутгийн иргэд гар болон гүний худгуудын усаар малаа усалж, ахуйн болон ундны хэрэгцээгээ хангадаг. Талбайд Баян усны, Харуулын гар худгууд байрлах ба эдгээр гар нь уурхайн худгуудаар хүн малын ундааны хэрэгцээш хангадаг.

2.4. Хөрсөн бүрхэвч

Тал хээрийн бүсийн хүрэн, цайвар хүрэн хөрс зонхилно. Мөн их бага халуун шаварт нуурын хөндий, Баян усны говь, Урт цагааны говь зэрэг газраар давсархаг сайрын хөрстэй. Энэ хөрс нь улаан шаварлаг хужир марз, гөлтгөнө ихтэй. Хөрсний бүтэц, найрлагаас хамаарч тэнд ургах ургамалын төрөл, өндөр нам зэрэг нь харилцан адилгүй бөгөөд хээрийн бор, цайвар хүрэн хөрсний онцлог нь чийг багатай жилийн ихэнхэд салхилах салхины нөлөөгөөр нүүдэл ихтэй байдаг.

2.5 Ургамалан нөмрөг

Хээрийн хүрэн, хар хүрэн хөрсний ургамалжилт нь малын тэжээлийн зонхилох хэсгийг бүрдүүлэх ба энд дааган сүүл, хазаар өвс, бутуул, ерхөг согоовор, хиаг, агь, таана зэрэг шим тэжээл сайтай өвс ургамал ноёрхох тул бэлчээрийн чанарын хувьд илүү сайн. Өндөр газар дэнж хажууд ерхөг, цагаан сүүл, дэрс голлон ургана. Зарим газар хялгана зонхилж ургасан нь ч бий.

Энэ төрлийн хөрс бүхий хэсгүүдэд ургац нягт, өндөр ургадаг тул хадлангаа эндээс бэлтгэдэг. Цагаан тэмээтийн говь, Гашууны хөндий, Гурван дэрсний говьд бударгана зонхилж таана, алтан харгана, хазаар өвс тачирхан ургасан байдаг. Сайргархаг хөрсөнд тохирсон сайрын хялгана, хазаар өвс, борог шавар, агь зэрэг ургамал ургана. Ургамалын ургалт хэдийгээр тачир боловч шим тэжээл сайтай мал тарга хүч авахад чухал нөлөөтэй боловч өвлийн улиралд цасан бүрхүүлд дарагдаж, бэлчээрийн нөөц хомсдох аюултай.

2.6 Амьтаны аймаг

Орон нутгийн газарзүйн онцлог цаг уурын нөхцөл зэргийг харгалзан, Монгол Дагуурын ба Хойд говийн тойрогт хамааруулан үзэж болох юм. Монгол Дагуурын тойрогт гол төлөв үлийн цагаан оготно, хэргэлзээт оготно, үхэр огдой, үурам, шар сүүлт, чичүүл зэрэг мэргэгчид туурайтнаас цагаан зээр, араатнаас үен, өмхий хүрэн, хярс, үнэг, мануул, илбэнх, дорго, чоно амьдардаг. Хойд говийн тойрогт үхэр огдой, сүүлт чичүүл, улаан шанаат зурам, алаг даага, туурайтнаас цагаан зээр, араатнаас үмхий хүрэн, хярс, чоно голлон амьдарна. Жигүүртнээс тас, элээ, сар, хэрээ зэрэг махчин шувууд байхаас гадна янз бүрийн жижиг шувууд болон болжмор элбэг байдаг.

ГУРАВ. ҮЙЛДВЭРЛЭЛ, УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1. 2026 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр:

2026 онд нийт 8649.96 мян/м³ хөрс, уулын цул 9649.96 мян/м³ хуулалт хийж 1000 м³ нүүрс олборлохоор төлөвлөн ажиллаж байна

3.2. Шимт хөрс хуулалт

Шимт хөрсийг бульдозер, 5.2 м³-ын утгууртай экскаватор, 91тн даацтай автосамосвалын хослолоор хуулна гэж тооцсон байна. Шимт хөрсийг ил уурхайн зүүн хойд болон баруун урд талд 250-300 м зайд 2 метрийн өндөртэйгөөр зөөвөрлөж хураана. Өрнөлтгүй болсон дотоод овоолго, ил уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ил уурхайн нөхөн сэргээлтийн үед ирээдүйн уулын ажлын өртөх талбайн шимт хөрсийг хуулж шууд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт ашиглах боломжтой.

3.3. Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж болно. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайд 14 хонон ажиллаж, 14 хоног амрах үндсэн ээлжтэй байна..Уурхай жилд 338 хоног ажиллана.

3.4. Уурхайн цахилгаан хангамж

Ил уурхай, засварын хэсэг болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээнд зарцуулна. Уурхайн ашиглалтын үед цахилгааны гурван хэрэглэгчтэй байна. Үүнд:

1. Уурхайн хэсэг
2. Засварын хэсэг
3. Аж ахуйн хэсэг

3.5. Цахилгаан эрчим хүчний үүсвэр

Уурхайн цахилгаан хангамжийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр дизель цахилгаан үүсгүүрийг авч төсөлд тусгасан байна. Энэ нь эдийн засгийн хувьд хөрөнгө оруулалт харьцангуй багатай хэдий ч ашиглалтын зардал өндөр байх хувилбар юм. Уурхай цаашид олон жил ажиллах мөн уурхайн хүчин чадал өсөх тохиолдолд цахилгааны хэрэглэгч нэмэгдэх магадлалтай тул Зүүн бүсийн эрчим хүчний системээс цахилгаан эрчим хүчээр хангах хувилбарын судлаж үзэх.

БНХАУ-д үйлдвэрлэсэн Emean үйлдвэрт үйлдвэрлэсэн VG-C138 загварын 100 кВт номиналь актив чадалтай дизель цахилгаан үүсгүүрийг ус зкайлуулах насосыг цахилгаанаар тэжээх зорилгоор, Ил уурхай болон хөрсний овоолгын гэрэлтүүлэг, шатахуун түгээх станцыг цахилгаанаар хангах зорилгоор VG-C41 загварын дизель цахилгаан үүсгүүр сонгож авсан.



Зураг 4. VG-C138, VG-C41 дизель цахилгаан үүсгүүрүүд

Уурхайн засварын газар тосгон болон уурын зуухыг цахилгаанаар хангах зорилгrrрх эдгээр хэрэглэгчдийн тооцооны цахилгааны ачаалал болох 394.47 кВт актив чадлыг үндэслэн БНХАУ-ын Kaihua үйлдвэрийн KH-400 загварын дизель үүсгүүр сонгож авсан.



Зураг 5. KH-400 дизель цахилгаан үүсвэр

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

4.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, бууруулах арга хэмжээ

УУР АМЬСГАЛ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас уур амьсгалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хур тунадастай өдрийн тоо нэмэгдсэнээр олборлолтын үйл явц саатах ✓ Аадар болон аянга цахилгаантай өдрийн тоо нэмэгдсэнээр техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа зогсолтод хүрэх ✓ Үер урсцын нөлөөгөөр төслийн талбайд их хэмжээгээр ус орсноор уурхайлалт түр зогсох 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг маш сайн хангаж ажиллах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорих шаардлагатай ✓ Техник хэрэгслийг талбайд гаргаж ажиллуулахгүй байх ✓ Зам, талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засаж бэлдэх
АГААРЫН ЧАНАР	
<p>Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийг тээвэрлэх, суурилах явцад тоосжилт ихээр үүсэх; ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж зам талбайн усалгааг сайтар хийх;
УСАН ОРЧИН	
<p>Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөц багасах; ✓ Ахуйн бохир усыг ил задгай хаяснаар хөрсний ус бохирдох; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүйн улмаас хөрсөнд нэвчилт үүсэх, ул хөрсний усыг бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэхгүй байх; ✓ Ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх, зориулалтын цэгт хаяж байх; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх;
ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хатуу хучилттай зам барих хүртэл газрын гадарга эвдрэлд өртөх болон хөрсөн бүрхэвч доройтох; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж баригдаж эхлэхээс өмнө сайжруулсан шороон замыг ашиглалтад оруулах,

<ul style="list-style-type: none"> ✓ Барилга байгууламжийн нөлөөгөөр газрын хэвлий болон хөрсөн бүрхэвч чанараа алдах; ✓ Төслийн дотоод зам, талбай болон гадна талбайд олон салаа зам гаргахгүй байх; ✓ Уурхайлалтаар хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх; ✓ Эрүүл талбайн өнгөн хөрс овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүсэх; ✓ Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон гадаргын урсцаар угаагдаж элэгдэх; ✓ Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах; 	<p>төслийн үйл ажиллагаа эхлэхэд хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулах;</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд маршрут гарган бусад хэсгээр тээврийн хэрэгслийг зорчуулахгүй байх; ✓ Тээврийн хэрэгслийн зогсоол, ногоон байгууламжийг зөв оновчтой төлөвлөх; ✓ Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу тогтмол усалж, шинж чанарыг хамгаалж, тордож байх
УРГАМЛЫН НӨМРӨГ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж, уурхайлалтын хэмжээгээр ургамлын нөмрөг бүрэн устгах; ✓ Төслийн талбайд автотээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагааны улмаас ургамал ургаж буй хэсгийг талхагдалд оруулах шиглагдаж буй тээврийн хэрэгслүүдээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамлын нөмрөгийг гэмтээх, бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд ногоон байгууламжийг оновчтой төлөвлөх; } Хог хаягдлыг тогтсон нэг цэгт байршуулах; ✓ Түлш, шатах тослох материалыг ашиглаж буй орчинд тэдгээрийг нэвтэрч шүүрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах ✓ Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган орчны ургамлын талхлагдахаас сэргийлэх;
АМЬТНЫ АЙМАГ	

<p>Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх; ✓ Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх; ✓ Олборлолт хийсэн нүхийг хашаалахгүйн улмаас мал, амьтан унах ✓ Цагаан зээр, хар сүүлтийн амьдрах орчинд нөлөөлөх 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: \</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн лицензийн талбайн хязгаарыг хэтрүүлэхгүй байх; ✓ Үйл ажиллагааны явцад улирлаар нүүдэллэн ирдэг амьтдын байрших гол газар, коридор нутагт тэдгээр амьтдыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх; ✓ Амьтны аймгийг хамгаалахын тулд судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын олон талт арга хэмжээг орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдтэй хамтран цогцоор хэрэгжүүлэх; ✓ Хууль бус ан хийгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох, хууль бусаар ан агнуур хийхгүй байх талаар ажиллагсад болон нутгийн иргэдэд тогтмол сургалт сурталчилгаа хийж байх;
<p>НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ</p>	
<p>Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шинээр ажлын байр бий болох; ✓ Улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх; ✓ Татварын орлого өсөх; 	

ТАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Харуул толгойн” хүрэн нүүрсний ордыг ил аргаар олборлох төслийн ТЭЗҮ хийгдэж 2024.11.25-ны өдөр Ашигт малтмал газрын тосны газрын даргын Т/145 тоот тушаалаар батлагдсан. “Байгаль орчны үнэлгээний тухай” хуулийн дагуу “Грийн ассесмент” ХХК нь уг төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн ямаар 2025.03.11-ний байдлаар баталгаажуулсан. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд үндэслэн холбогдох хууль, дүрэм, стандартуудыг баримтлан жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан түүнийг мөрдөн ажиллана.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь

“Харуул толгойн хүрэн нүүрсний ордыг ашиглах” уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээр зорин ажиллаж байна. Уурхайн тухайн жилийн зорилтын хувьд үйл ажиллагаа явуулах талбайн зохион байгуулалтын байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар төлөвлөх, газрын эвдрэл бага байлгах, шимт хөрсний хуулалт стандартын хүрээнд гүйцэтгэж ажиллах төлөвлөгөөтэй болно.

Төслийн баримтлах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нарийвчилсан үнэлгээний хүрээнд эхний жилд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэх, байгаль орчны холбогдолтой баримт бичгүүдийг бүрдүүлэн ажиллах, уурхайн байгаль орчны холбогдолтой журам, дүрэмийг боловсруулах, хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх уурхайн хяналтын цэгүүдийг тогтоох, “Тэрбум мод” хөтөлбөрийн дагуу уурхайн хөтөлбөрийг боловсруулах, Дүйцүүлэн хамгаалах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэх хог хаягдлын менежментийн тогтсон системтэй болоход тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллахад чиглэгдэх болно.

Хүснэгт 2. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7500.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9000.0
3	Дүйцүүлэн хамгаалах, арга хэмжээний төлөвлөгөө	7000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2200.0
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2030.0
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь	-
	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	29,230,000

5.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал Төг	Тоо хэмжээ	Нийт зардал, Төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр									
1	Төслийг хэрэгжүүлэх үед нийт 763.2 га талбай нөлөөлөлд өртөхөөс олборлолтын явцад 528.7 га талбай хүчтэй нөлөөлөлд өртөх ба хамгийн ихдээ 132 м гүнтэй ил уурхайн ухаш үүсэж үлдэнэ.	Газар хөндөх зөвшөөрлийн дотоод журам боловсруулан газар шорооны бүхий л ажлын үед мөрдөн ажиллах.	Уурхайн хэмжээнд	журам	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйл Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага. Газрын хэвлийн тухай хуулийн 20 дугаар зүйл Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг
	Уурхайн тосгон, уурхайн захиргааны байрнаас гарсан хатуу, шингэн хог хаягдлаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Хатуу хог хаягдлыг ангилан ялгалт хийж хогийн түр цэгт хаях ба Дорнод аймгийн Матад сумын хогийн цэгт булшлах, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг цэг хүргэж өгөх	Уурхайн хотхонд хогийн цэг байгуулах	0.09 га			Хогийн цэг төлөвлөх		
2. Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр									
	Төслийн үйл ажиллагаанаас хүлэмжийн хий ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх. Машин тоног төхөөрөмжийн түлшний шаталтаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг авч үзвэл нүүрс хүчлийн хийд шилжүүлсэн дүнгээр нүүрсхүчлийн хий (CO ₂) 29570 тн, метан (CH ₄) 34.6 тн, азотын хоёрч	Хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх,	Төслийн хүрээнд бүртгэл хөтлөх	тн/CO ₂	Зардал шаардагдахгүй	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Жилд нэг удаа	*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг

исэл (N2O) 2341 тн, нүүрсний ил уурхайгаас ялгарах метан (CH4) 12417 тн, нийт хүлэмжийн хийн ялгарал нүүрс хүчлийн хийд шилжүүлсэн дүнгээр жилд дунджаар 44363 тн байна.								тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж)		
3. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр										
Хаягдал чулуулаг болон нүүрс ачих үйл ажиллагаанаас үүсэх тоосны хэмжээ уурхайн хэмжээнд жилд дунджаар 337.4-404.0 тн, уурхайн дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосны хэмжээ жилд дунджаар 1092.2 1278.8 тн, тоос тоосонцор үүсэхээр байна.	Ил уурхайд тоосжилтыг бууруулах тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх, олборлолтын бүсэд тоосжилт үүсч буй зам талбайг тогтмол услах	Ил уурхайн хэмжээнд	43.4 га			-	2500.00	5000.00	Үйл ажиллагаа эхэлмэгц дулааны улиралд тоосжилт өндөр үед өдөр бүр усалгаа хийх	MNS 4596:2007, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм Агаарын тухай хууль Усны тухай хууль, 5-р бүлэг, 32.8
Уурхайн шороон болон сайжруулсан дотоод замуудаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж агаарыг бохирдуулах	Дулааны улирлын халуун, хуурайшилт ихтэй үед шороон замыг тоос дарагч бодис бүхий усаар усан чийгшүүлэх	Ил уурхайн бүх замуудад	1.2 км /2.4 га/							
Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр										
Ил уурхайн ухаш, ХЧО, уурхайн дотоод зам үүссэнээр гадаргын түр урсцын голдрилыг хаах мөн тус уурхайн дотоод зам үерийн усанд автах, ил уурхайд үерийн ус орж ирэх	Гадаргын түр урсац уурхайн ухаш болон хөрсний овоолго, дотоод зам руу орохоос сэргийлж уурхайн баруун хэсэгт орших дотоод замыг дагуулан үерийн уснаас хамгаалах далан суваг бий болгох.	Нүүрсний уурхайн шаардлагатай талбайд тойруулан	43.4 га			-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Усны тухай хууль, 21 дүгээр зүйл
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр										
Нүүрсний орд ашиглах төслийн хэрэгжүүлсний үр дүнд нийт 763.2 га талбайн хөрс хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөнө. 483.0 га талбайд ил уурхай үүсэж, тус талбайн хөрсөн бүрхэвч бүхэлдээ устана.	Ил уурхай болон хаягдал чулуулгийн гадаад овоолгын хөрс хуулалтын ажил эхлэхийн өмнө өнгөн хөрсийг 0.3 метр зузаантайгаар хуулж, 5 метрээс ихгүй өндөртэй	Стандартын шаардлага хангасан шимт хөрсний овоолго	6 га			-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан		MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5914:2008 “Эвдэрсэн

Бусад барилга байгууламжийн үүдэх сөрөг нөлөөлөлд 14.2 га талбайн хөрс өртөх	овоолго хэлбэржүүлж шимийг хадгалах	үүсгэн үржил	үүсгэх, хадгалах						газрын нөхөн сэргээлт. “Газрын тухай” хууль 50 дугаар зүйл
Уурхайн үйл ажиллагаатай холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсч улмаар хөрсний эвдрэл, доройтол бий болох	Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд болон холбогдох газарт байршуулах		Замуудын уулзвар бусад холбогдох газруудад тэмдэг байршуулах	10-15 ш	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	-	MNS 5915:2008 “Уул уурхай үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” MNS 3473:1993 “Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт
Уурхайн бусад барилга байгууламжийн талбайн хөрсөн бүрхэвч хуулагдана	Эвдрэлд орох талбайн үржилт шимт хөрсийг 0.3 метр зузаантайгаар хуулан шимт хөрсний овоолгод байршуулна.		Үйл ажиллагааны талбай	500.0	-	2500.0			
Ургамал болон амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр									
Нүүрсний овоолго болон нүүрс ачиж буулгах явцад тоосжилт үүснэ. Дээрх үүссэн тоосжилтоос уурхайн хэсгийн болон түүний ойр орчмын ургамлан нөмрөгийн морфологид өөрчлөлт орох, фотосинтезийн эрчим буурах	Ургамлан нөмрөгийн мониторингийн ажлыг жил бүр тогтмол явуулж, нөлөөллийг тогтоож бууруулах		Нүүрсний ил уурхай хэмжээнд	Ургамлын мониторингийн цэг байгуулах	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Жилд 2 удаа	Геоботаникийн бичиглэл хийх арга, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995, Ургамал хамгааллын тухай хууль, 2007 7-р дугаар зүйл, “Амьтны тухай” хууль (6.1.7)
Салаа зам гарснаас бэлчээрийн чанар доройтох, талхлагдах	Замын мэдээллийг (хуучин, шинэ) улирал бүр бүртгэж шинэчлэн зураглаж, холбогдох арга хэмжээ авахдаа ашиглах		Нүүрсний ил уурхай болон тээврийн замын хэмжээнд	Замын бүртгэл	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Улирал тутам	
Нийт зардал, төг						7,500,000			

5.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын 13 дахь жилд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд 14 дэх жилээс биологийн нөхөн сэргээлт хийгдэхээр төслийн БОННУ-ний тайланд тусгагдсан. Тус 2026 онд уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх төлөвлөгөөтэй тул тус онд уурхайн нөхөн сэргээлтийн арга хэмжээг төлөвлөгөөгүй болно. Уурхайн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан хөрс хамгаалах, ил уурхайн болон хотхон байгуулах талбай болон бусад зам талбайн хөрсийг маш сайн стандартын дагуу хуулж хадгалах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Мөн уурхайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд аймгийн БОАГ, болон Матад сумын ЗДТГазрын саналаар тухайн нутагт эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр төлөвлөх, дүйцүүлж нөхөн сэргээлт хийх боломжтой.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Төслийн үйл ажиллагаанаас уурхай орчмын газрын гадарга, дэд бүтэц, бусад дагалдах байгууламж элэгдэл, эвдрэлд өртөх	Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудын өнгөн шимт хөрсийг хуулах, шимт хөрсний овоолго үүсгэж хадгалах	га	6.0	500,0	3000.00	Уулын ажил гүйцэтгэхээс өмнө шим хөрс хуулалт хийх	Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
2.	Уурхайн хотхонд ногоон байгууламжийн төлөвлөлт, мод тарих ажлыг гүйцэтгэх	Уурхайн хотхонд ногоон байгууламжийн төлөвлөлт, мод тарих ажлыг гүйцэтгэх	Га	1.8	Модны суулгац авах, талбай бэлтгэх зардал	1000.0	Хавар, намар Уурхайн хотхонд мод тарих ажил	MNS:5918:2023 эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага
3.	Орон нутгийн санал хүрээнд гүйцэтгэх ажил	Аймгийн Байгаль орчны газрын саналын дагуу эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт гүйцэтгэх	га	1.5	-	5000.0	6-7 сарын хооронд	
Нийт зардал, төг						9,000,000		

5.3 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын Их хурлын тогтоолоор 2012 оны 05-р сарын 17-ны өдөр батлагдсан “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 4.2-р зүйлд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д үаасан биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг дараах зарчмыг хангасан байна” гэж заасан байна.

“Харуул толгойн хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эмзэг тогтоц бүхий хээрийн экосистемийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тодорхой зардлыг төлөвлөсөн болно.

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ, биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох, төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд сум орон нутгийн Байгаль орчны газартай хамтран ажиллах, мөн тухайн газрын санал болгосон ажил, арга хэмжээг гүйцэтгэх өөр эвдэрсэн газруудад техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэхээр төлөвлөсөн болно.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая/төг	Нийт зардал сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баритмлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8
1.	Дүйцүүлэн хамгаалах газрын хэмжээ, биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох, төлөвлөгөө боловсруулах.	Мэргэжлийн байгууллагын оролцоотой биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үнэлгээ, судалгаа хийх,	Мэргэжлийн байгууллага, аймгийн БОГ, Матад сумын ЗДТГ хамтран ажиллах	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Жил нэг удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль
		Бусад эвдэрсэн газар талбайд, дүйцүүлж нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэх /аймгийн санлын дагуу/	Уурхайн ойролцоо нутагт	-	7000,0	5000.0	Жил нэг удаа	
Нийт зардал, төг						7 000.000		

5.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ханзо майнинг” ХХКомпанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас 35-км-ын радиуст барилга байгууламж болон нутгийн малчдын хашаа байхгүй учраас уурхайгаас бүсэд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

Байгаль орчин, хүн, малын эрүүл мэнд, тээврийн үйл ажиллагааны аюулгүй байдалд эрсдэл үүсэх нөхцөл харьцангуй одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа болон, замын зурвасын нөлөөллийн бүсэд орон нутгийн айл өрх, өвөлжөө, хаваржаа байхгүй тул “Ханзо майнинг” ХХК-ийн зүгээс орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажил 2026 онд төлөвлөгдөөгүй болно.

5.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Архиологийн хайгуул судалгааг МУИС-ийн ШУС-ийн НУС-ийн Антропологи, археологийн тэнхимийн докторант Ч.Амарбилэг ахлагчтай судалгааны баг “Ханзо майнинг” ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу 2021 оны 07-р сарын 06-наас 12-ны хооронд хайгуулын талбайд очиж хээрийн судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна.

Тус судалгааны анги нь хайгуулын талбайд “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д заасны дагуу ямарваа нэгэн түүх, соёл, археологийн тэнхимийн 2 оюутаны хамт, Улаабаатар -Чойбалсан- Матад- Хашаат- Матад- Чойбалсан-Улаабаатар гэсэн маршрутаар хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын хүрээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалд хамаарах зүйлийг илрүүлээгүй. Уул уурхайн ажлын явцад хөрс хуулалт болон бусад ажлын явцад хүний нүдэнд ил мэдэгдэх шинж тэмдэггүй ямар нэгэн дурсгал эд өлгийн зүйлс олдвол мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж зөвлөгөө мэдээлэл авах. Тусгай зөвшөөрлийн талбайд археологийн ямар нэгэн биет дурсгалыг бүртгэн баримтжуулж аваагүй боловч газар шорооны ажлын явцад санаандгүйгээр түүх соёлын дурсгалд холбогдох эд өлгийн зүйлс олдсон тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагад хандахыг зөвлөсөн.

Палентлогийн судалгааг Дорнод аймгийн Баянтүмэн, Матад сумдын нутагт орших XV-021435 тоот “Хашаат ” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улсын ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн академич Р.Барсболд, судлаач, палеонтологич Б.Энхбаатар, Д.Идэрсайхан нар палеонтологийн хайгуул тандан судалгааны хээрийн ажлыг 2021 оны 07-р сарын 2 ноос 5-ны өдрүүдэд хийж, ажиглалтын цэг бүрд координат авч тэмдэглэн, тухайн цэгүүдийн бичиглэлийг дэлгэрэнгүй бичиж, гэрэл зургаар баримтжуулан гүйцэтгэсэн. Уг ажлыг гүйцэтгэх явцад ашигт малтмалын хайгуулын талбайд гадаргуугийн хайгуул судалгаагаар палеонтологийн үлдвэр илрээгүй. Хэдийгээр соёлын өвд хамаарагдах палеонтологийн үлдвэр илрээгүй ч тус талбайд эртний амьтан ургамлын болон бусад олдвор агуулсан байх магадлалтай хурдас ихээр тархсан байгааг анхаарахгүй орхиж болохгүйг тэмдэглэсэн.

5.6 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, Төг	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	7	8	
1	Галын аюул: Барилга байгуулалтын үед ашиглагдах химийн бодисууд дотор ахуйн болон үйлдвэрлэл, техникийн зориулалттай олон тооны шатах, тэсрэх болон хялбархан исэлддэг бодисууд хэт халалтын улмаас тэсрэх дэлбэрэх, исэлдэх зэрэг эрсдэл учруулах Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх	Ил уурхайн байгууламжууд	Байнга	Үйл ажиллагааны зардалд тусгасан		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 дүгээр заалт	
		Галын дохиоллын систем суурилуулах, гол унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах	Уурхайн байгууламж, ажилчдын кемп	Байнга	3,000,000	3,000,000	Байнга	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16.1 заалт, 18.1 заалт, 19.1 заалт, 20.1 заалт, 21.1 заалт	
		Бүх химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгаан эх үүсвэрээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах	Химийн бодисын агуулах	-	-	Тооцох боломжгүй	Жилд	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний	
2	Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах	Тэсэрч дэлбэрэх аюултай түлш, шатах тослох материалыг нарны шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах, хамгаалалтын чанга дэглэм тогтоох	Тэсрэх бодисын агуулах	-	Зураг төсөл, төлөвлөлтийн зардалд тусгах		Төлөвлөлтийн шатанд	Галын аюулгүй байдлын тухай хууль, заалт 16.1, заалт 18.1, заалт 19.1, үаалт 20.1, заалт 21.1	
		Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах	Уурхай, уурхайн ажилчдын кемп	-	-	2026 оны компанийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм, 4-р хавсралт
		Төслийн талбай газар хөдлөлтийн идэвхтэй бүсд байдаггүй боловч барилга байгууламжийн байршлыг холбогдох төрийн захиргааны байгуулалатай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөх	Уурхайн байгууламж, ажилчдын кемп	-	Зураг төсөл, төлөвлөлтийн зардалд тусгах		Барилга байгууламж баригдахаас өмнө	Дэд бүтцийн сайдын тушаал Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22-01-01	

3	Газар хөдлөлт	Бохир усны шугам хоолой цоорч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах эрсдэлтэй тул дамжуулах шугам, хоолойг байнга шалгах шаардлагатай, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхай	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-	-
4	Үйлдвэрлэлтэй холбоотой осол	Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийг галын онц аюултай байгууламжид зориулсан стандартын дагуу хийж тогтмол шалгах	Уурхайн байгууламж, цахилгаан станц		Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-	MNS: 4628-1998 19х Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага
		Шатахууны агуулахын монтажны бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Шатахууны агуулах		Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-	MNS:4244-1994 61х Хөдөлмөр хамгааллын систем налын аюулгүй байдал ерөнхий шаардлага
		Галын аюулаас хамгаалах болон ил гал гаргахыг хориглосон анхааруулсан тэмдэг, санамж, зурагт самбар, тэмдэглэгээ хийх	Шатахууны агуулах, уурхай		Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-	Гамшгийн тухай хууль, аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
		Осол гарсан үед хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Ил уурхайн ам	-	Тооцох боломжгүй	-	
Нийт зардал, төг			2,200,000				

5.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж түүний дагуу төлбөр төлөх	Дорнод аймгийн, Матад сум,	Сар бүр	1935.0	12	2026 оны ҮАЗ-д тусгагдсан.	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
		Орчны хог хаягдалд тогтмол хяналт тавьж, сар тутам орчны цэвэрлэгээг гүйцэтгэх	Кемп, оффис	удаа		12		сард 1 удаа	
		Ахуйн хэрэгцээнээс гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг орон нутгын зохих газарт тушаах, дахин ашиглагдах боломжгүй хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх	Хогийн цэг	-	250,000	4	1,000,000	Тухайд бүрд	
2	Үйлдвэрийн	Засварын газраас гарах аюултай хаягдлын бүтгэл үүсгэх, хэмжээг бүртгэх, хаягжуулах	Гэрээт гүйцэтгэгч компаниуд	Сар бүр	-	12	Зардал шаардахгүй	Дотоод журамд заасны дагуу	Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
		Хаягдал дугуй сум орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу хүлээн өгөх, шаардлагатай тохиолдолд дахин ашиглах	Засварын газар, хуучин сэлбэгийн агуулах, ШТС	ш, тонн	Зардал шаардахгүй	2	ҮАЗ-д тусгагдсан	Тухайд бүрд	
3	Аюултай	Аюултай хаягдал авах тусгай зөвшөөрөл бүхий эрх бүхий ААН-д гэрээ байгуулах, гэрээний дагуу	“Ханзо Майнинг” ХХК Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	-	Зардал шаардагдахгүй		2026 оны эхний улирал	Жил 2 удаа	
		Аюултай хаягдлыг гэрээний дагуу тусгай зөвшөөрөлтэй этгээдэд шилжүүлэх, тээвэрлүүлэх нийлүүлэх ажиллагаа гүйцэтгэх			1.200.000				
Нийт зардал							2,200,000		

5.8. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх бүхэл сөрөг нөлөөллийн хамгийн бага байлгах аар тооцож байгаль орчны удирдлагын зохион байгуулалтын төлөвлөгөөтэй ажиллана.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал.төг	Хариуцсан албан тушаалтан
1	Уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардагдах төлөвлөгөө, гэрээ, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллана.	1-р улиралд багтаан	Шаардлагагүй	Уурхайн захиргаа Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн
2	Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай гүний худаг гаргах зөвшөөрлийн холбогдох газраас авах	1-р улиралд багтаан	500,000	
3	Уурхайн 2026 оны Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах, Хэрлэн голын сав газартай ус ашиглах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах	1-р улиралд багтаан	1,000,000	Байгаль орчны мэргэжилтнүүд,
5	Уурхайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний өмнөх жилийн үр дүнд аймгийн БОАЖГазрын мэргэжилтнүүдийн хамт хяналт хийх	5 сар	Шаардлагагүй	Байгаль орчны мэргэжилтэн
6	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд цаашид хийх ажлыг төлөвлөх талуудын уулзалтыг зохион байгуулж авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах	5 сар	Шаардлагагүй	Аймгийн БОАЖГ, Матад сумын ЗДТГ, Ханзо Майнинг ХХК ,
7.	Байгаль орчны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, талаар ажлын бүтэн, хагас жилийн тайланг Матад сумын ЗДТГ-т, Аймгийн БОАЖГ-т, БОУХБ-д мэдээлж байх	жилд 2 удаа	-	Байгаль орчны мэргэжилтнүүд
8.	Харуул толгой уурхайн ус ашиглалтын бүтэн болон хагас жилийн тайланг боловсруулан Хэрлэн голын сав газар, Усны газар ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагт хүргүүлж байх	жилд 2 удаа	6, 12 сарын 25 ны дотор	Байгаль орчны мэргэжилтнүүд
	Нийт:		1,500,000	

5.9 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Д/д	Тайлан мэдээ	Тайлан мэдээ хүргүүлэх байгууллага	Мэдээний агуулга	Хугацаа	Хэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах ажилтан
1	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 сарын 10-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлагнах, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн сум багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 сарын 10-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	
3	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 сарын 10-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	


5.10 2026 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Харуул толгойн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжүүлэгчээс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд туснасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт бий болж болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Д/д	Хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян\төг	Нийт зардал,\мя н.төг\жил\	Баримтлах стадарт ба арга аргачлал
1	Агаарын бохирдлын үзүүлэлт	Агаар орчны бохирдол, агаар дахь тоосны агууламж NO ₂ , SO ₂ , TPS, PM ₁₀ , PM _{2.5} Дуу шуугиан, Температур харьцангуй чийгийн хэмжээ.	(мг/м ³)	* - агаарын мониторингийн цэгүүдийг доорхи зурагт харуулав.	Жилд 2 удаа	Уурхайн орчны хяналт шинжилгээний хяналтын цэгт	NO ₂ , SO ₂ , CO, Тоос 50,000*8= 400,000	800,000	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
1.	Хөрсний ерөнхий үржил шим болон хүнд металлын бохирдлын шинжилгээ	Хөрсний химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн	Хөрсний ерөнхий үзүүлэлт, ялзмаг	* - хөрсний мониторингийн цэгүүдийг доорхи хүснэгтэнд харуулав.	Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээний хөрсний хяналтын 4-н хяналтын цэгт	Хөрс 58000*3*1= 174.000	Хөрс 400.000	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага” MNS 3298:1991
2		Хөрсний бохирдлын үзүүлэлтүүт	Хөрсний хүнд металлууд				Хүнд металл 60000*5*1= 180.000	180.000	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2008
1	Унд ахуйн хэрэглээний бүх гүний худгийн усанд шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргах	Унд ахуйн усны химийн ерөнхий шинжилгээ	Ерөнхий хатуулаг, рН, цахилгаан дамжуулах чадвар, өнгө, атуулаг, хлорид,	Гал тогооны ус	Жилд 2 Удаа	Унд ахуйн хэрэглээний бүх гүний худгийн усанд шинжилгээ хийлгэхэд	45000*3*1= 135000	270,000	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 900: 2005
			Кемпийн худгийн ус Ундны худаг,						

			аммони, нитрит, нитрат, фтор, фосфат,						
2		Унд ахуйн усны бактерлоги болон микробиологийн шижилгээ	Бактерлогийн шинжилгээ	Гал тогооны ус			$60000*1*2=$ 120,000	120,000	
3	Технологийн усны шинжилгээ	Усны хүнд металлын шинжилгээ	Усны хүнд металлын шинжилгээ	Ундны худаг Технологийн худаг	Жилд нэг удаа	-	$65000*2=$ 130,000	260,000	-
							Нийт төсөв	2,030,000	

Хүснэгт 8 Мониторингийн цэгүүдийн байршил



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Ханзо майнинг ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Хавсралт 2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл,

Хавсралт 3. ТХГН-ын тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагаа

Хавсралт 4. Уурхайн батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний нүүр

Хавсралт 6. Хяналтын хуудас

Хавсралт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дээж авах хяналтын цэгүүдийн байршилын зураг

Хавсралт 8. 2026 оны уулын ажлын дэвсгэр зураг